



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/566

Мөрөн

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-гийн "а" заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 61 дүгээр тогтоол, ИТХ-ын ээлжит XV хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 9 дүгээр багийн иргэн Хатанбаатар овогтой Бүрэнсодном 2 нас 3 сартай тархины саажилт, дахилттай таталт өвчний улмаас "Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв"-д төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлж онош тодруулж эмчлүүлэх шаардлагатай учир нэг удаагийн эмчилгээний зардалд 283040 /Хоёр зуун наян гурван мянга дөчин төгрөг/-ийн дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх мөнгөн тусламжийг "Эрүүл мэндийг дэмжих" хөтөлбөрийн санхүүжилтээс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Х.Ган-Очир / нарт зөвшөөрсүгэй

ДАРГА



Л.ГАНБОЛД